



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2009 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/363

Мандалговь

Ажлын хэсгийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.10, 10 дугаар зүйлийн 10.2.5 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн байгалийн шинжлэх ухааны хичээлд ашиглагдаж байсан, чанарын шаардлага хангахгүй болсон химийн бодис, урвалжийг аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах чиглэлээр эрх авсан аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, устгуулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Гантулга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Анхцэцэг (Боловсрол, шинжлэх ухааны газрын байгалийн ухааны боловсрол хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Б.Хандмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Л.Дорждэрэм (Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч)

З.Наранмандах (Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Т.Цог-Эрдэнэ (Тагнуулын хэлтсийн ажилтан, дэслэгч)

Ш.Бямбасүх (Цагдаагийн газрын Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад)

4822111204

2. Ерөнхий боловсролын сургуулиудад хадгалагдаж байгаа чанарын шаардлага хангахгүй болсон химийн бодис, урвалжийг шилжүүлж, устгуулах үйл ажиллагааг чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (Н.Гантулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

